

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/115/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: Munguntsetseg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41000 Дархан-Уул аймаг,
Дархан-Уул, 14-р баг,
Утас: 7327-2029, Факс: 9719-7327-1089,
E-mail: darhanuul@auditor.mn

2021.12.11 № 07
талай -чиглэл

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
А.АМГАЛАН ТАНАА



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дэглэд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шааргагач эгтгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд эсхистэй нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагагүй гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойли, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа болсон материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа бичиг юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дөнгөөрөө эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгшлэлийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй бэйлэл материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АДЭМҮҮГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР



009020076

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	118.5	127.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,947.7	2,883.7
	Нийт хөрөнгийн дүн	3,066.3	3,011.1
	Нийт ер төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,066.3	3,011.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,066.3	3,011.1
	Үйл ажиллагааны орлогын дүн	919.6	1,232.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,039.4	1,286.6
	Үйл ажиллагааны үр дүн	(119.7)	(54.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(4.7)	(0.9)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(124.5)	(55.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,194.8	3,066.3
	Тайлант оны үр дүн	(124.5)	(55.2)
	Эцсийн үлдэгдэл	3,066.3	3,011.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	774.2	1,042.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	764.8	1,009.2
	Үйл ажиллагааны ЦМГ	9.4	33.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(9.4)	(33.5)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	648.3	620.7
	Урсгал зардал	648.3	620.7
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	648.3	620.7
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51.8	37.3
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596.5	580.5
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын ЗДТГ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Дархан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 29,680.0 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээ, 6,247.7 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 212,883.6 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлснээс 250.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 212,633.6 мянган төгрөгийн алдаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

Төлбөрийн акт

Аудитаар программист, архив, бичиг хэргийн ажилтан Б.Дөлгөөнд мэргэжил олгох сургалтын зардалд 250.0 мянган төгрөгийг хүүхэд хамгааллын зардлаас зарцуулсан зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

Зөвлөмж

Тус байгууллагын 2021 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас Аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар байгууллагын дарга А.Амгаланд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 926.5 мянган төгрөгийн мөнгөн шагналыг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын ангилалд ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд хамаарна ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаад зөвлөмж хүргүүлсэн.

Хүүхдийн эрх хамгаалал хариуцсан мэргэжилтэн /Хүүхдийн эрхийн улсын байцаагч/-ийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг албан тушаалын тодорхойлолтоор “ТЗ-5”-аар баталсан боловч Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д “улсын байцаагч” нь “ТЗ-6” ангилалд хамаарч байгаатай холбогдуулан тус байгууллагын даргын 2021 оны Б/08 дугаар тушаалаар “ТЗ-6” ангиллаар цалинжуулсанд зөвлөмж хүргүүлсэн.

Тус байгууллага нь “Би хариуцлагатай аав, ээж аян”, “Дархан хүү 2021” арга хэмжээнүүдийг гүйцэтгүүлэхээр “Бүтээлч залуус нэмэх мөрөөдөл” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, 4,636.4 мянган төгрөгийн санхүүжилт өгсөн боловч гүйцэтгэлд хяналт тавиагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн журналыг байгууллагын эд хөрөнгийн тооллогын дүнтэй тулгахад барилга байгууламж 186,053.3 мянга, машин, тоног төхөөрөмж 800.0 мянга, тавилга эд хогшил 20,217.4 мянга, нийт 207,070.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь байгууллагын даргын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/116 дугаар тушаалаар эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг 2021.12.06-2021.12.08-ны өдөр зохион байгуулсантай холбоотойгоор 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс хойш орлогод авсан хөрөнгүүдээс шалтгаалжээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1. “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” заалттай нийцэхгүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	6	212.9			1	0.3			5	212.6
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		6	212.9			1	0.3			5	212.6